



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

### 「Нийслэлийн хүүхдийн 201 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхээс хандивласан 9,944,000.0 (есөн сая есөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн хүүхдийн 201 дүгээр цэцэрлэг (Ш.Доржхорол)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 201 дүгээр цэцэрлэг (Ш.Доржхорол)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *Т. Оюунтуул* ОЮУМАА







Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаалын хавсралт

БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: 201 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Пийшин	Хятад	4 ширэм	2025	шинэ	ш	1	3,630,000.00	3,630,000.00	Тайваны	
2	Шарах шүүгээ	Хятад	2x4	2025	шинэ	ш	1	3,300,000.00	3,300,000.00	хүүхэд гэр бүлийг дэмжих сан	Хандив
3	Ус буцалгагч	Хятад	20л	2025	шинэ	ш	1	264,000.00	264,000.00		
4	Жигнүүр	Хятад	12 тавиур	2025	шинэ	ш	1	1,650,000.00	1,650,000.00		
5	Хөлдөөгч	Хятад	200л	2025	шинэ	ш	1	1,100,000.00	1,100,000.00		
Нийт бүртгэх хөрөнгийнг дүн								9,944,000.0			